

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/013-НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2025 он	Аудитор: Ж.Цогт Утас: 7036-2442 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10-13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	12
4. Аудитын тайлан	14-16
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	17-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20-21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХС	Аймаг хөгжүүлэх сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төрийн албан хаагч
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



“СЭЛЭНГЭ ОРОН СУУЦ” ОНӨААТҮГ
-ЫН ЗАХИРАЛ Г.ЗОЛБОО ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.08.15 № СНА-2025/013-НД-СНА-ОНӨАТҮГ
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2023 оны эцэст бүртгэгдсэн 1,308,639.3 мянган төгрөгийн “Аймаг хөгжүүлэх сан”-гийн зээлийн үлдэгдлээс тайлант онд 1 хоршоо, 4 аж ахуйн нэгж, 14 иргэний нийт **333,537.1** мянган төгрөгийн зээл бүрэн төлөгдөж, 14 аж ахуйн нэгжийн 573,302.6 мянган төгрөгийн, 30 иргэний 401,607.6 мянган төгрөгийн зэрэг нийт **974,910.2** мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Аудитын гол асуудал

Тус газар нь өөрийн эзэмшлийн 7,139 м.кв газарт 30 айлын 4 блок буюу нийт 120 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр холбогдох зураг төсөв, техникийн нөхцөл зэрэг шаардлагатай баримт бичгийг бүрдүүлсэн байна.

43250233²

Бусад асуудлын хэсэг

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь тайлант онд 3 зорилт, 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.1 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь *(Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл)* санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		01-р сарын 01	12-р сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	6,382,715,393.33	6,389,965,820.24
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,991,142,562.16	3,369,579,006.02
1.1.4	Авлага	4,390,252,831.17	3,020,386,814.22
1.1.4.1	Дансны авлага ТӨҮГ	3,081,805,549.17	2,045,476,567.22
1.1.4.2	Бусад авлага	1,308,447,282.00	974,910,247.00
1.1.9	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,320,000.00	
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	6,382,715,393.33	6,389,965,820.24
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	19,567,035.24	683,770,947.24
1.2.1	Үндсэн хөрөнгө	30,284,039.00	30,284,039.00
1.2.2	Хуримтлагдсан элэгдэл	(10,717,003.76)	(15,469,091.72)
1.2.3	Биет бус хөрөнгө		668,955,999.96
1.2.4	Программ хангамж		1,320,000.00
1.2.5	Хуримтлагдсан элэгдэл		(440,000.04)
1.2.6	Бусад биет бус хөрөнгө		668,076,000.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	19,567,035.24	19,567,035.24
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,402,282,428.57	7,073,736,767.48
2	Эргэлтийн бус хөрөнгө		
2.1	ӨР ТӨЛБӨР		1,087,070.19
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		1,087,070.19
2.1.1.4	Татварын өглөг /ТӨҮГ/		1,087,070.19
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	1,087,070.19
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өглөг		-
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.1.2.20	Өр төлбөрийн нийт дүн	-	1,087,070.19
2.1.2.21	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,402,282,428.57	7,072,649,697.29
2.2	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	4,338,969,532.22	5,007,045,532.22
2.2.1	Өмч : а) төрийн	908,960.00	908,960.00
2.2.3	в)ТӨҮГ	4,338,060,572.22	5,006,136,572.22
2.2.4	Хувьцаат капиталын дүн	4,338,969,532.22	5,007,045,532.22
2.2.8	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	2,063,312,896.35	2,065,604,165.07
2.2.20	Эзэмшигчдийн өмчийн дүн	6,402,282,428.57	7,073,736,767.48
2.3.20	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	6,402,282,428.57	7,073,736,767.48

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх тайлант үеийн дүн	Тайлант улирлын дүн
1	Борлуулалтын орлого /цэвэр/	116,506,781.39	194,250,640.93
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	197,291,951.13	189,659,097.19
3	Нийт ашиг (алдагдал)	(80,785,169.74)	4,591,543.74
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	104,745,129.50	184,567,775.93
6	Ногдол ашгийн орлого		
7	Алдангийн орлого	11,761,651.89	9,682,865.00
8	Бусад орлого	-	
9	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	122,211,511.13	183,379,939.00
11	Санхүүгийн зардал	25,080,440.00	
12	Бусад зардал /ТӨҮГ/	50,000,000.00	1,087,070.19
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
16	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол		5,192,088.00
17	Бусад ашиг /алдагдал/		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(80,785,169.74)	10,870,701.93
19	Орлогын албан татвар	-	1,087,070.19
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(80,785,169.74)	4,591,543.74
21	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(80,785,169.74)	4,591,543.74

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг алдагдал	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,338,969,532.22	2,071,154,213.52	6,410,123,745.74
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт		72,943,852.57	72,943,852.57
8	Тайлант үеийн цэвэр ашиг		(80,785,169.74)	(80,785,169.74)
11	2023 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	4,338,969,532.22	2,063,312,896.35	6,402,282,428.57
13	Залруулсан үлдэгдэл	-	-	-
14	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт		(2,300,275.02)	(2,300,275.02)
16	Өмчид гарсан өрчлөлт	668,076,000.00	-	668,076,000.00
18	Тайлант үеийн цэвэр ашиг		4,591,543.74	4,591,543.74
19	Ногдол ашиг			-
21	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,007,045,532.22	2,065,604,165.07	7,072,649,697.29

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх тайлант үеийн дүн	Тайлант үеийн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	116,506,781.39	194,250,640.93
1.1	Мөнгөн орлогын дүн	116,506,781.39	194,250,640.93
1.1.1	Бусад мөнгөн орлого	116,506,781.39	194,250,640.93
1.2	Мөнгөн зарлагын дүн	197,291,951.13	183,379,939.00
1.2.1	Ажилчдад төлсөн	70,588,844.46	108,562,310.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,064,259.56	13,362,654.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	6,627,361.99	4,136,250.00
1.2.8	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	16,340,400.00	13,900,000.00
1.2.12	Бусад мөнгөн зарлага	94,671,085.12	43,418,725.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(80,785,169.74)	10,870,701.93
1.4	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,299,448,500.79	1,367,565,741.93
1.5	Мөнгөн орлогын дүн	1,299,448,500.79	1,367,565,741.93
1.6	Мөнгөн зарлагын дүн	25,080,440.00	-
1.6.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	23,760,440.00	
1.6.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,320,000.00	
1.6.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,299,448,500.79	1,367,565,741.93
1.7	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,274,368,060.79	1,367,565,741.93
1.8	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	50,000,000.00	-
1.9	Мөнгөн зарлагын дүн	50,000,000.00	-
1.9.1	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	50,000,000.00	-
1.20	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(50,000,000.00)	-
1.21	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,143,582,891.05	1,378,436,443.86
1.22	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	847,559,671.11	1,991,142,562.16
1.23	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,991,142,562.16	3,369,579,006.02

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСӨВ	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт орлого	1,041,071,015.72	1,554,433,792.88	(513,362,777.16)	149.31
2.1	Борлуулалтын орлого	916,071,015.72	1,360,183,151.95	(444,112,136.23)	148.48
2.2	АВЛАГА	916,071,015.72	1,360,183,151.95	(444,112,136.23)	148.48
2.2.1	Төрийн албан хаагчдын орон сууцны зээлийн барагдуулалт	705,827,096.04	973,503,259.95	(267,676,163.91)	137.92
2.2.2	Сумдад хэрэгжсэн орон сууцны зээлийн барагдуулалт	60,243,919.68	62,825,722.00	(2,581,802.32)	104.29
2.2.3	Аймаг хөгжүүлэх сангийн авлага барагдуулалт	150,000,000.00	323,854,170.00	(173,854,170.00)	215.90
2.3	Үндсэн үйл ажиллагааны орлого	125,000,000.00	194,250,640.93	(69,250,640.93)	155.40
2.3.1	Хүү, алдангийн орлого	125,000,000.00	194,250,640.93	(69,250,640.93)	155.40
3	Нийт зарлагын дүн	3,221,726,457.77	183,379,939.00	3,038,346,518.77	5.69
3.1	Цалин нийгмийн даатгалын шимтгэл	174,226,457.77	121,924,964.00	52,301,493.77	69.98
3.2	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	154,867,962.46	108,562,310.00	46,305,652.46	70.10
3.2.1	Үндсэн цалин	92,692,936.56	76,290,709.00	16,402,227.56	82.30
3.2.2	Нэмэгдэл цалин	47,250,614.52	23,610,063.00	23,640,551.52	49.97
3.2.3	Урамшуулал	7,724,411.38	4,923,538.00	2,800,873.38	63.74
3.2.4	Унаа хоол	7,200,000.00	3,738,000.00	3,462,000.00	51.92
3.3	Ажил олгогчоос төлөх НДШ12.5%	19,358,495.31	13,362,654.00	5,995,841.31	69.03
4.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,047,500,000.00	61,454,975.00	2,986,045,025.00	2.02
4.1.1	Бичиг хэрэг	5,600,000.00	2,041,100.00	3,558,900.00	36.45
4.1.2	Тээвэр шатахуун	18,000,000.00	13,900,000.00	4,100,000.00	77.22
4.1.3	Сургалт семинарын зардал	2,000,000.00	-	2,000,000.00	-
4.1.4	Дотоод албан томиллолт	6,000,000.00	2,842,000.00	3,158,000.00	47.37
4.1.5	Шуудан холбоо	1,200,000.00	674,850.00	525,150.00	56.24
4.1.6	Бага үнэтэй ТҮЭ	1,000,000.00	2,095,150.00	(1,095,150.00)	209.52
4.1.7	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,500,000.00	1,600,000.00	900,000.00	64.00
4.1.8	Техник, тоног төхөөрөмж	10,000,000.00	-	10,000,000.00	-
4.1.9	Ашиглалтын зардал /байрны түрээс/	1,200,000.00	1,000,000.00	200,000.00	83.33
4.1.11	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал	3,000,000,000.00	37,301,875.00	2,962,698,125.00	1.24
5	Нийт ажиллагсдын тоо	5.00	3.00	2.00	60.00
5.1	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
5.2	Мэргэжилтэн	2.00	1.00	1.00	50.00
5.3	Нягтлан бодогч	1.00	1.00	-	100.00
5.4	Архив, бичиг хэрэг	1.00	-	1.00	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь “Сэлэнгэ аймгийн хүн амыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, төрөөс зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн хүн амыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлого, чиг үүргийг хэрэгжүүлэх,*
- Гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлээс санхүүжилтийн эх үүсвэр татах ажлыг олон хэлбэрээр зохион байгуулах замаар хөрөнгийн тогтвортой сан бүрдүүлж, барилгын хөрөнгө оруулалт, зээл санхүүжилтийг цогцоор нь шийдвэрлэх,*
- Төрийн өмнөөс аймгийн нутаг дэвсгэрт орон сууц бариулах ажлыг зохион байгуулах,*
- Төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагатай орон сууц, үл хөдлөх хөрөнгийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор гэрээгээр болон хамтарсан аж ахуйн нэгж байгуулах зарчмаар хамтран ажиллаж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх,*
- Залуу гэр бүл болон төрийн албан хаагчдад чиглэсэн орон сууцжуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, урт хугацааны, хямд түрээсийн орон сууцны менежментийг хэрэгжүүлэх,*
- Сумдын төрийн албан хаагчдыг орон сууцжуулах ажлыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан эхлүүлэх гэх мэт.*

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал буюу 100.0 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 53 дугаар тогтоолоор байгуулагдсан байна.

Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх “Орон нутгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна”: 20.1.9: “орон сууц, нийтийн аж ахуй”, 35 дугаар зүйлийн 35.1 дэх “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 35.1.12: орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй: ... 4/ “орон нутгийн

өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 680,033.8 мянган төгрөгөөр буюу 10.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,991,142.6	3,369,579.0	1,378,436.4
Нийт авлага	4,390,252.8	3,020,386.8	(1,369,866.0)
Авлага /орон сууц/	3,081,805.5	2,045,476.6	(1,036,329.0)
Авлага /АХС/	1,308,447.3	974,910.2	(333,537.0)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,320.0	-	(1,320.0)
Үндсэн хөрөнгө	19,567.0	683,770.9	664,203.9
Нийт хөрөнгө	6,402,282.4	7,073,736.8	671,454.4
Богино хугацаат ер төлбөр	-	1,087.1	1,087.1
Урт хугацаат ер төлбөр	-	-	-
Эздийн өмч	6,402,282.4	7,073,736.8	671,454.4
Нийт ер төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,402,282.4	7,073,736.8	671,454.4

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,369,579.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,378,436.4 мянган төгрөгөөр өссөн нь АХС болон ТАХ-ийн орон сууцны зээлийн эргэн төлөлтөөс,
- Авлагын дансны үлдэгдэл 3,020,386.8 мянган төгрөг болж, 1,369,866.0 мянган төгрөгөөр буурсан нь ТАХ-ийн 120 айлын орон сууцны эргэн төлөлтөөс 973,503.3 мянган төгрөг, Алтанбулаг, Баянгол, Цагааннуур сумын орон сууцны эргэн төлөлтөөс 62,825.7 мянган төгрөг, АХС-ийн зээлийн үлдэгдлээс 333,537.0 мянган төгрөгийг барагдуулснаас,
- Урьдчилж гарсан зардал данс үлдэгдэлгүй тайлагнагдсан нь эхний үлдэгдлийг тайлант хугацаанд санхүүгийн программыг үндсэн хөрөнгийн орлогод бүртгэснээс,
- Нийт хөрөнгийн үлдэгдэл 671,454.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 10,870.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан болон 668,076.0 мянган төгрөгийн газрыг үнэлж хөрөнгийн дансанд бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/09 дүгээр захирамжаар “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2024 оны төлөвлөгөөг баталж, авлагын барагдуулалтыг 916,071.0 мянган төгрөгөөр, үндсэн үйл

ажиллагааны орлогыг 125,000.0 мянган төгрөгөөр, нийт орлогыг 1,041,071.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,221,726.4 мянган төгрөгөөр тус тус тогтоосон байна.

Гүйцэтгэлээр авлагын барагдуулалтаар 1,360,183.1 мянган төгрөг, хүү алдангийн орлого 194,250.6 мянган төгрөг, нийт 1,554,433.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаанд 183,379.9 мянган төгрөгийн зардал гарган, 10,870.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлого 1,554,433.8 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдан, төлөвлөгөөг **513,362.8** мянган төгрөгөөр буюу 49.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 183,379.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 3,038,346.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь цалин, НДШ-ийн зардлыг 52,301.5 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны зардлыг 2,962,698.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн *Ишинээр орон сууц барихаар зардал төлөвлөсөн боловч хэрэгжээгүй* - ээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын

тайлангийн нийт авлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт авлагын 4,390,252.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **43,902.5** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг мөрдөж, баталсан төлөвлөгөөний хүрээнд ил тод байдлыг ханган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын мэдээлбэл зохих 28 төрлийн 170 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл, худалдан авах ажиллагаа нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 174 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 18,223.3 мянган төгрөгийн 5 зөрчил илрүүлж, 4,558.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 13,665.0 мянган төгрөгийн 2

зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 2 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 80.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	4,558.3	1	4,558.3	100.0
Албан шаардлага	2	13,665.0	2	11,410.0	100.0
Зөвлөмж	2	-	1		50.0
Нийт дүн	5	18,223.3	4	15,968.3	80.0

Өмнөх аудитаар өгөгдсөн зэрэгцээ хөдөлмөрөөр нягтлан бодогчийн албан тушаалыг эрхлүүлж буй зөрчлийг таслан зогсоох зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, ... эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10: *"аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"* гэсэн заалтуудыг үндэслэн **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус үйлдвэрийн газарт 2023 оны жилийн эцэст бүртгэгдсэн 1,308,639.3 мянган төгрөгийн АХС-ийн зээлийн үлдэгдлээс тайлант онд 333,537.1 мянган төгрөгийн зээл төлөгдөж, 974,910.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

АХС-ийн зээлийн үлдэгдлээс тайлант онд **333,537.1** мянган төгрөгийг /1 хоршоо, 4 ААН байгууллага, 14 иргэний зээл бүрэн төлөгдсөн/ барагдуулсан байна. Үүнд:

- *"Зэлтэр хүрхрээ хоршоо"-ны нийт 6,617.0 мянган төгрөгийн,*
- *"Бага буурагчин" ХХК, "Сэлэнгэ буудай" ХХК, "Ганмон энжелс" ХХК, "Зүүвч ивэн бургалтай" ХХК-ийн 220,470.5 мянган төгрөгийн,*
- *14 иргэний нийт 106,449.6 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлээс хасаж тооцсон байна.*

2024 оны жилийн эцэст тус үйлдвэрийн газарт 14 аж ахуйн нэгжийн 573,302.6 мянган төгрөгийн, 30 иргэний 401,607.6 мянган төгрөгийн нийт **974,910.2** мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл тайлагнагдсан байна. Үүнд:

- Нийслэлийн ШШГГ, аймгийн ШШГГ, Мандал, Сайхан сумын ШШГХ-ийн гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа 29 зээлдэгчийн 601,691.7 мянган төгрөгийн,
- Нас барсан 4 зээлдэгчийн 102,500.0 мянган төгрөгийн,
- Гадаадад байгаа 2 зээлдэгчийн 33,930.0 мянган төгрөгийн,
- Шүүхээр эвлэрлийн гэрээ байгуулсан 3 зээлдэгчийн 56,100.0 мянган төгрөгийн,
- Эрэн сурвалжилж байгаа 2 зээлдэгчийн 45,000.0 мянган төгрөгийн,
- Тогтмол төлж (эвлэрүүлэн зуучлалаар орсон) байгаа 1 зээлдэгчийн 70,800.0 мянган төгрөгийн,
- Шүүхэд эвлэрэлд хүргүүлсэн боловч хүрэлцэн ирээгүй 1 зээлдэгчийн 15,863.0 мянган төгрөгийн,
- Сэлэнгэ цэнгэг ус ОНӨААТҮГ-тай холбоотой 49,025.5 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

Цаашид хугацаа хэтэрсэн 7 зээлдэгчийн 144,110.6 мянган төгрөгийн зээлийн асуудлыг гэрээний дагуу хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх, өмнө гарсан шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авч үлдэгдэл авлагыг бүрэн барагдуулах нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **16,029.5** мянган төгрөгийн 2 зөрчил илэрч, албан шаардлага хүргүүлээ.

5.1 Албан шаардлага:

1. Төрийн албан хаагчтай байгуулсан “Орон сууц захиалгаар барих гэрээ”-ний үүргийн биелэлтийн дагуу төвлөрүүлэх орлогоос 1 албан хаагчийн **6,817.1** мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, Төрийн албан хаагчтай байгуулсан “Орон сууц захиалгаар барих” гэрээний 2.2 дахь “Захиалагч нь үл хөдлөх эд хөрөнгийн төлбөрийг энэхүү гэрээнд заасан хуваарийн дагуу төлнө” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргийн биелэлтийг хангуулах албан шаардлага хүргүүлэв.

2. Аймгийн ГХБХБГ-т үндсэн орон тооны нягтлан бодогчоос гадна зэрэгцээ “Хөдөлмөрийн гэрээ”-гээр аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэж буй Б.Уранчимэгийг хөдөлмөрийн гэрээгээр нягтлан бодогчоор ажиллуулан нийт **9,212.4** мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх “Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ” 37.1.17: “Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх”, 38 дугаар зүйлийн 38.1 дэх

“Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ”, 38.1.6: “Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх”, 38.1.7: “Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх...”, Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 84 дүгээр зүйлийн 84.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТАХ-ийн орон сууцны гэрээт орлогыг дутуу төвлөрүүлсэн.	1	6,817.1			1	6,817.1						
Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.	1	9,212.4			1	9,212.4						
Дүн	2	16,029.5			2	16,029.5						